

ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2025.01.17

Эрдэнэт хот

2023 оны 05 дугаар сарын 04-ны өдөр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдаж тус хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу Нийгмийн даатгалын газрын даргын 2023 оны А/24 тоот тушаалаар байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороог байгуулан, доорх бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулан ажиллаж байна. Тус дэд хороонд 2024 оны байдлаар 1 иргэнээс төрийн албан хаагчийн үйл ажиллагаа, ёс зүйтэй холбоотой 1 гомдол ирсэн ба иргэд даатгуулагчаас Нийгмийн даатгалын газарт 142 санал хүсэлт ирснийг журмын дагуу хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан.

д/д		Овог нэр	Албан тушаал
1.	Дарга	М.Дүүрэнжаргал	Тэтгэмжийн улсын байцаагч
2.	Гишүүн	Л.Эрдэнэсүвд	Орлого, шимтгэлийн улсын байцаагч
		Д.Дуламсүрэн	Хяналт, шалгалтын улсын байцаагч
		Б.Эрдэнэчимэг	Тэтгэврийн улсын байцаагч
3.	Нарийн бичгийн дарга	Д.Идэржавхлан	Хүний нөөцийн мэргэжилтэн

Ёс зүйн дэд хороо нь Төрийн албан хаагчдын сахилга хариуцлага, ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах зорилгоор шинээр батлагдан гарсан хууль, журам тогтоол шийдвэрүүдийг өөрийн байгууллагын онцлог, чиг үүрэгтэй уялдуулан жилийн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байгаагийн дээр Төрийн албаны зөвлөлийн Орхон аймаг дахь салбар зөвлөлийн 2024 оны “Арга хэмжээ зохион байгуулах тухай” 57 тоот албан бичигт дурдсан “Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд” ирүүлсэн асуудлуудын график үзүүлэлтийг танилцуулан, төрийн байгууллагын хүнд суртал, төрийн албан хаагчийн ёс зүй харилцаа хандлагатай холбоотой санал хүсэлт гомдол ихээхэн хувийг эзэлж байгаа тул Нийгмийн даатгалын байгууллагын ажилтануудыг ёс зүйн зөрчлөөс урьдчлан сэргийлэх, харилцаа хандлагыг сайжруулах, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх зорилгоор сургалт арга хэмжээнүүдийг шат дараатайгаар хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд:

1. 2024 оны Ёс зүйн дэд хорооны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан томоохон ажлын нэг болох “ **Хэн нь ёс зүйтэй ажилтан бэ**” богино хэмжээний зохиомжит

нэвтрүүлгийг нийгмийн даатгалын газрын ажилтануудын дотоод фэйсбүүк групп байршуулан, ажлын байран дээр бид иргэд даатгуулагчидтай харилцахдаа санаатай болон санамаргүй байдлаар ийм ёс зүйн алдаа гаргадаг юм биш биз дээ гэсэн сэдлийг өгөх зорилгоор бэлтгэн хүргэсэн. *Зураг-1*

2. Нийгмийн даатгалын байгууллагын ажилтан албан хаагчдаас 13 асуумж бүхий тандалт судалгаа авч судалгааны үндсэн дээр цаашид авах арга хэмжээ болон ёс зүй харилцаа хандлагаас болж гардаг голлох асуудлууд дээр илүү анхаарч үйл ажиллагаагаа сайжруулахаар зорин ажиллаж байна. *Зураг-2*

3. 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Ёс зүйн дэд хороо болон Ёс зүйн дэд хорооны гишүүн Л.Эрдэнэсүвд Нийгмийн даатгалын байгууллагын нийт ажилтан албан хаагчдад Монгол улсын ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам” болон 2023 онд шинээр батлагдсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн ойлголт, хуулийн зорилго зорилт, ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээ, шаардлагын талаарх сургалт зохион байгуулж нийт 43 албан хаагч хамрагдсан байна.

4. Монгол Улсын Их хурлын 2024 оны ээлжит сонгууль болохтой холбоотойгоор Ёс зүйн дэд хорооны Гишүүн Л.Эрдэнэсүвд 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдөр Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг баримтлан үүрэг, хариуцлагаа ухамсарлан ажиллах, аливаа нам эвсэл улс төрийн үйл ажиллагаанд оролцохгүй байх талаар Төрийн албан хаагчдад мэдээлэл хүргэж ажиллалаа.

5. МУ-ын Засгийн газрын 2024.10.02-ны өдрийн "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ" батлах тухай 109 дүгээр тогтоолыг албан хаагчдад танилцуулж, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журманд өөрчлөлт оруулсан тухай сургалтыг Хүний нөөц хуулийн мэргэжилтэн Д.Идэржавхлан ажилтан албан хаагчдад сургалтаар орж нийт 29 ажилтан албан хаагч хамрагдсан байна.

6. 2024.10.11-ний өдөр Нийгмийн даатгалын ерөнхий газраас нийгмийн даатгалын салбарын албан хаагчдын дунд хууль тогтоомжийн хэрэглээний ур чадварыг дээшлүүлэх сэдвээр сургалт зохион байгуулсан бөгөөд Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайханы “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийн талаарх сургалтад 25 албан хаагчийг цахимаар хамруулж ажиллалаа.

7. Мөн 2024.10.28-ний өдөр Нийгмийн даатгалын салбарын албан хаагчдад “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн онцлох заалтын талаарх цахим сургалт зохион байгуулахад тус газрын 31 албан хаагч цахимаар хамрагдсан.

8. Тус газар нь 2018 оноос хойш ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд уг стандарттай холбоотойгоор дагалдах журмуудыг боловсруулан ажиллаж байна. Эдгээрээс Нийгмийн даатгалын байгууллагын “Үйлчлүүлэгчтэй харилцах журам”-ыг батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байгаа нь албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчлан сэргийлэх томоохон түлхэц болж байна. Дээрх журмыг хэрэгжилтийг сайжруулах зорилгоор Ёс зүйн дэд хорооны зүгээс төлөвлөгөөт бусаар шалгалт хийж, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

9. 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдөр Ёс зүйн дэд хорооны гишүүн Д.Дуламсүрэн МУ-ын Засгийн газрын 2023 оны 469 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм” болон “Нийгмийн даатгалын улсын байцаагчийн дүрэм”-ийн талаарх сургалт орж нийт 35 албан хаагч хамрагдлаа.

10. 2024 оны 10 сарын 25-ны өдөр "Тогтвортой хөгжлийг сайжруулах ил тод байдлыг нэмэгдүүлэх БЭСТ хөтөлбөрийн хүрээнд тус төвөөс зохион байгуулсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн сургалтад тус газрын Ёс зүйн дэд хорооны 5 гишүүн, мөн Шилэн дансны мэдээлэл байршуулах үүрэг бүхий ажилтан Үйл ажиллагааны нягтлан бодогч Т.Даваажаргал, Сангийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн Б.Раяа, нээлттэй байршуулах мэдээлэлд хяналт тавих албан тушаалтан (Санхүү бүртгэлийн тасгийн дарга) нар хамрагдаж мэдлэг боловсролоо дээшлүүлсний дээр уг сургалтаас олж авсан мэдээллийг боловсруулан төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдал, хадгалалт нууцлал, анхаарах асуудал зэргээр нийт албан хаагчдад мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан.

11. Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар нь Төрийн байгууллагуудаас анх удаа Авлигын эсрэг стандарт нэвтрүүлсэн бөгөөд 2024 оны 02 дугаар сард Монсертф ХХК-ны тохирлын үнэлгээний байгууллагаас тус газрын хэрэгжүүлсэн ISO37001:2016 Авлигын эсрэг менежментийн тогтолцооны хэрэгжилтэд Магадлах аудит хийж хангалттай үнэлгээ авсан тул менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын гэрчилгээг 2027 он хүртэл сунгахаар шийдвэрлэсэн бөгөөд нийгмийн даатгалын газрын ажилтан албан хаагч, байцаагчид 2024 онд авлига ашиг, сонирхолын болоод ёс зүйн зөрчилгүй ажиллаж байна.

12. Тус оны хэмжээнд дэд хороонд ёс зүйн зөрчлийн талаар ажилгүйдлийн тэтгэмж авагч Б.Анхбаярын ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэн ажилласан. Тус өргөдөлтэй холбоотой шаардагдах баримт материал, утасны ярианы бичлэг бусад нотолгоог бүрдүүлэн дэд хороо хуралдан ёс зүйн зөрчил биш гэж дүгнэлт гарган холбогдох дээд шатны удирдлагад хүргүүлэн ажилласан байна.



13. Газрын ёс зүйн дэд хороо нь тус онд улирал бүр мэдээ тайланг гарган НДЕГ-ын ёс зүйн хороо, Төрийн албаны зөвлөлийн Орхон аймаг дахь салбар зөвлөлд тус тус хугацаанд нь хүргүүлэн ажилласан байна. Ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлсэн төрийн байгууллага болж манлайлан ажиллахаар зорьж ажиллаж байна.

Богино хэмжээний видео.



Зураг-1

Судалгааны асуумж



Зураг-2

Сургалтын үйл ажиллагаа






ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗАРЧИМ

- хүнлэг, энэрэнгүй байх;
- үнэнч, шударга байх
- хариуцлагатай байх;
- манлайлах;
- хамтач байх.

ТАХЁЭЗТХууль 7 бүлэг 19 зүйл

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 7 ДУГААР ЗҮЙЛД /ТӨРИЙН АЛБАНЫ ЗАРЧИМ/

- ард түмэнд үйлчлэх;
- мэргэшсэн, тогтвортой байх;
- улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх;
- Монгол Улсын иргэн төрийн алба хаах адил тэгш боломжоор хангагдах;
- төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлах;
- ил тод байх;
- ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
- захирах, захирагдах ёсыг баримтлах.





ТАЙЛАН ХЯНАСАН:

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА.....М.ДҮҮРЭНЖАРГАЛ

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА.....Д.ИДЭРЖАВХЛАН